



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

“Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/530 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсыг олон улсад сурталчлах, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2023 оны 8 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд, 2023 оны 9 дүгээр сарын 09, 10-ны өдөр “Япон Соёлын Наадам 2023” соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах 88 760 000 (наян найман сая долоон зуун жаран мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА

D. Batm

Д.БАТСҮХ



1150500216

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 08 сарын 24 өдрийн
А/39 дугаар тушаалын хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН

2023 оны 08 дугаар сарын 24-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1. СОЛОНГОСЫН СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨДРҮҮД				
1	Төв тайзны лед дэлгэц Нийт хэмжээ: 18*5м Нэгж хэмжээ: 50*50см 08 дугаар сарын 25,26,27-ны өдрүүдэд/	360	3 өдөр* 27,500₮	29,700,000₮
2	Хөгжмийн иж бүрдлийн инженерүүдийн ажиллах зардал /08 дугаар сарын 25,26,27-ны өдрүүдэд/	Багц	3 өдөр* 3 500 000	10 500 000
4	Микрофоны түрээс	30 ширхэг	3 өдөр 50 000	4 500 000
5	Дижитал консол түрээс	1	3 өдөр 1 000 000	3 000 000
6	Синтезаторы 88 цахилгаан төгөлдөр хуур түрээс	1	3 өдөр 500 000	1 500 000
7	Тог, цахилгаан зардал	Багц	3 өдөр* 200 000	600 000
8	Цагаан сандал түрээс	100 /3 өдөр/	3 өдөр* 3500	1 050 000
9	Хүндэт зочдын буудлын зардал (Мэга Макс хамтлаг 7 гишүүн)	6 өрөө	5 өдөр 323 000	9 690 000
Хэсгийн дүн				60 540 000
2. "ЯПОН СОЁЛЫН НААДАМ" 2023				
1	Тайз, Карказ, Хөгжим, Лед	Багц	2 өдөр	19 000 000
2	Цагаан сандал түрээс	100 ширхэг	2өдөр 3 500	700 000
3	Асар түрээс	40 ширхэг	2 өдөр 99 000	7 920 000
4	Тог тайз	Багц	2 өдөр 200 000	600 000
Хэсгийн дүн				28 220 000
Нийт дүн				88 760 000

--- оОо ---